



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026. 06. 11 № 1/1195
танай 2026. 06. 08 -ны № 02/2785 -т

Төлөвлөгөөний хэрэгжилт хүргүүлэх
тухай

Эрүүл мэндийн яамнаас ирсэн 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 02/2785 дугаар албан бичгийн чиглэлийн дагуу “Эрүүл мэндийн салбарын шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2026 оны эхний хагас жилийн байдлаар нэгтэн гаргаж, хүргүүлж байна.

Хавсралт 11 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



П.АНХТУЯА


142261895


ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ 2026 ОНД САЙЖРУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Төлөвлөгөөний хэрэгжилт
1	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд улирал тутам дүн шинжилгээ хийх, дутуу мэдээллүүдийг байршуулах, тус арга хэмжээг хэвших	Хувь	80%	Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд шаардлагатай мэдээллүүдийг тогтмол шинэчилж, олон нийтэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд 2026 оны I “Шил ажиллагаа” нэгдсэн системийн үнэлгээгээр 94 хувийн үзүүлэлттэй үнэлэгдсэн. Цаашид II улиралд үнэлгээний үзүүлэлтийг нэмэгдүүлэх, мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэг 94% 98% Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 89% Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 94% Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 97% Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал 88% Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал Хаах  Зураг 1. Мэдээллийн ил тод байдлаас https://shilen.gov.mn/index/65a548c793eea62a7ed0862a?type=BRANCH&year=2026&season=1 линкээр орж үзнэ үү. https://www.unte.moh.gov.mn/home линкээр орж үзнэ үү

2	Байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, Олон нийтэд сурталчлах:	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд түгээсэн мэдээллийн тоо, зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн тоо	- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр улирал бүр 3-с доошгүй мэдээлэл гарсан байна - 2-с доошгүй удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна - Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ зэрэгт тухай бүр мэдээлэл байршуулсан байх	Тайлант хугацаанд байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, сургалт, өдөрлөг болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас, албан ёсны фейсбүүк цахим хаяг болон мэдээллийн бусад сувгаар дамжуулан тухай бүр олон нийтэд түгээсэн. Тайлант хугацаанд 10 видео мэдээлэл, 101 зурагт мэдээллийг боловсруулан байршуулж, байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Тайлант хугацааны сүүлийн 90 хоногийн байдлаар байгууллагын цахим хуудсанд нийт 1,081,701 удаагийн хандалт бүртгэгдсэн. https://www.facebook.com/profile.php?id=61553436448298  Зураг 2. Хандалтын тоо
3	Олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчуулсан эерэг бичлэг, сэтгэгдэл, пост мэдээлэл цахим системд оруулах зэрэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Хамтран ажилласан олны танил хүний тоо, хийлгэсэн сурталчилгааны тоо	Олны танил 5-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байх	Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж үйлчилгээ болон эрүүл мэндийн боловсролыг олон нийтэд сурталчлах зорилгоор байгууллагын туршлагатай, олны танил эмч, мэргэжилтнүүдийн оролцоотой нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр нийт удаагийн 11 видео контент бэлтгэн байгууллагын цахим хуудас болон албан ёсны сошиал сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Мөн эмч, мэргэжилтнүүдийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг мэдээ, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлийн мэдээллийг тогтмол түгээж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр ажилласан.

				
				Зураг 3. Контентын явцаас
4	Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён	Нийт албан хаагчдын баталгаа гаргасан байдал /хувиар/ - Сургалтын тоо	Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх - 2-оос багагүй сургалт	Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, албаны мэдээллийг албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх чиглэлээр: 1. “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-г цахим болон лекц, сургалт хэлбэрээр, мөн “Хөдөлмөрийн дотоод журмын хориглох заалтууд”-г дэлгэрэнгүй видео хичээл, лекц хэлбэрээр таниулах үйл ажиллагааг нийт 692 ажилтнуудад хүргэв. 2. Шинэ ажилтны чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөрийн дагуу шинэ ажилтнуудад ажлын цаг ашиглалтын журам, хөдөлмөрийн дотоод журам болон эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг танилцуулах сургалтад нийт 34 шинэ ажилтныг хамруулав. 3. Төрийн бус байгууллагаас сэтгэлзүйч, лектор Г.Наранбаатар, лектор, сургагч багш Д.Мягмардорж нарыг урьж "Жаргалтай амьдралын суурь", "Байгууллагын үнэт зүйлс" сэдвүүдээр нийт 542 ажилтнуудыг хамарсан сургалтыг зохион байгуулав.  Зураг. Сургалтын явцаас


гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах

- Цаг бүртгэлийн журмын дагуу 14 хоног тутам тохиолдлоор тасаг нэгжийг сонгон, тус тасаг нэгжийн ажилтнуудын цаг бүртгэлийн мэдээллийг хянан шалгаж, захиргааны 5 давхарт байрлах дэлгэц дээр нийтэд ил тодоор байршуулах, ирцийн бүртгэлийг сайжруулах ажил өрнөж байна.



Зураг. Нийтэд нийтэлсэн байдал

- Энэ нөлөөллийн арга хэмжээний үеэр тухайн хугацаанд цаг бүртгэл хангалтгүй байсан албан хаагчдад “Дотоод мемурандум” –г Захиргаа, хүний нөөцийн албанаас албан хаагчийн албаны и-мэйл хаягаар хүргэн, сануулга болгон илгээж байна. 2026.05.31-ны байдлаар 3 ажилтанд дотоод мемурандум илгээсэн.



Зураг. Ажилтанд илгээсэн и-мэйл

- Төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусад хууль бус давуу байдал олгохгүй байх чиглэлээр ажилтнуудыг соён гэгээрүүлж 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Авлигатай тэнцэх газрын ажилтан, комиссар Д.Балдандорж "Авлигын гэмт хэргийн тухай ойлголт" сэдвээр нийт 140 нэгжийн дарга, эрхлэгч, их эмч нарт эхний удаагийн сургалтаа зохион байгуулав. Үргэлжлүүлэн сувилагч, тусгай мэргэжилтэн, захиргаа, дэмжих албаны ажилтнуудад хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.



Зураг. Сургалтын явцаас

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/380 дугаар тушаалаар “Цаг бүртгэлийн журам” батлагдсан. Уг журмын шинэчлэн батлах ажил эхэлсэн ба үүнтэй холбоотойгоор 2026.04.02-ны өдрөөс 2026.04.13-ны хооронд нийт ажилтнуудаас журамд нээлттэй санал авахаар албаны и-мэйл хаягаар нийтэд мэдээллийг түгээв. Ирсэн нийт ажилтнуудын саналыг хэлэлцэн авч үзэж, журмыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.



Зураг. Нийт ажилтнуудад илгээсэн и-мэйл


5

Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийх, хүнд суртал чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж,арилгахад чиглэсэн арга хэмжээ


Хийгдсэн дүн шинжилгээ, үр дүнд суурилсан зохион байгуулсан арга хэмжээний тоо





- Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх
- Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх


Орны хүлээгдэл: Нийт судалгаанд хамрагдсан 513 өвчтөний 62.6% нь хэвтэх шаардлагатай гэж зөвлөснөөс хойш 3 хоногт багтан эмнэлэгт хэвтэж чадсан бөгөөд 35.9% шууд хэвтэж чадсан байна. 15-аас 30 хоногийг хүлээгдэл 6.8%, 1 сараас дээш хоногийн хүлээгдэл 7.6% байна.



Амбулаторийн үзлэгийн цаг товлол, хүлээгдэл: Судалгаанд хамрагдсан нийт 356 үйлчлүүлэгчийн 93.8% нь эмчид үзүүлэх цаг захиалан тусламж үйлчилгээнд хамрагдсан бөгөөд үйлчлүүлэгчдийн 17.5% нь 1800-0119 тусгай дугаар руу залгаж, 17.5% нь E-mongolia аппликейшнээр, 65% нь өөрийн биеэр ирж эмчид үзүүлэх цаг захиалсан



				Товлогдсон цагтаа тусламж үйлчилгээ авч чадсан эсэх  ■ Товлогдсон цагтаа үзүүлсэн ■ Хүлээсэн ■ Хүлээж чадалгүй орхин явсан Эмчийн үүдэнд хүлээсэн хугацаа 
6	Албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа авах нь авлигын зөрчил болох талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг тусгайлан зохион байгуулах (кейс бүхий дэвжээ, АХА бусад уралдаан тэмцээн зохион байгуулж болно)	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	2-оос багагүй нөлөөллийн ажил зохион байгуулах	<u>Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд бидэнд таны чин сэтгэлийн талархал – Баярлалаа гэдэг үг л хангалттай</u> сэдвээр 2025 оны 10 сард шторк бичлэг үүсгэн, олон нийтэд хүргэх, ард иргэдийг уриалах зорилгоор УНТЭ-н facebook хуудас, youtube хуудас, УНТЭ-н хамт олны facebook хуудас дээр нийтэлсэн. Уг уриалган сэргээн идэвхжүүлж, 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр дахин тус цахим сүлжээгээр нийтлэх, түгээх ажлыг эхлүүлэв.   Зураг. Олон нийтийн хуудсууд дээр нийтэлсэн байдал


			Монгол улсын Авлигатай тэнцэх газраас хэвлэн гаргасан: - Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага - Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага зэргийг алба тасаг нэгж болгоны эрхлэгч, дарга нарт олгохоор зарлал тарааж, олгох ажил явагдаж байна.  Авлигатай тэнцэх газраас олгосон ГАРЫН АВЛАГА тараах тухай НВ Захиргаа, хүний нөөцийн алба · fb@bvtm.mn to rullm · Өдрийн мэд. Монгол улсын Авлигатай тэнцэх газраас хэвлэн гаргасан: - Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага - Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага зэргийг албан хаагчдад тусгаж чиглэлийн дагуу тарагдах болсон тул Та бүхэн Захиргааны 5 дэвхрэн 502 тоот өрөө буюу Захиргаа, хүний нөөцийн албаны даргын өрөөнөөс ирж авч уу. Хамтран ажилласанд баярлалаа. Захиргаа, хүний нөөцийн алба Reply Forward Share in chat Зураг. Тараах ном болон зарлал мэдээллийн и-мэйл
7	Харьяа төрийн байгууллагуудаас үзүүлж буй үйлчилгээнд иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнгээс хамаарах арга хэмжээ зохион байгуулах	Судалгаа, үр дүнд суурилсан зохион байгуулсан арга хэмжээний тоо	Сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнд суурилсан арга хэмжээ зохион байгуулсан байх Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын 5.8, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/340, 2023 оны А/113 дугаар тушаалыг үндэслэн Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийж тусламж үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгсэл болгож хэвшүүлэх. Амбулаторийн тусламж, үйлчилгээний сэтгэл ханамж : Судалгаанд хамрагдсан нийт 356 үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 83.7% байна. Үүнээс ЭМДТ 91.1%-иар хамгийн өндөр, СЗЭТ 78.7%-иар хамгийн бага үнэлэгдсэн. Амбулаторийн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 

				<table><tr><th>Тасаг, төвийн нэр</th><th>“5” маш сайн</th><th>“4” сайн</th><th>“3” дунд</th><th>“2” муу</th><th>“1” маш муу</th><th>Дундаж үнэлгээ</th></tr><tr><td>Амбулатори</td><td>32.8%</td><td>50.6%</td><td>10.8%</td><td>2.5%</td><td>3.3%</td><td>81.4%</td></tr><tr><td>ДОТ</td><td>37.5%</td><td>51.6%</td><td>6.3%</td><td>3.1%</td><td>0.0%</td><td>83.8%</td></tr><tr><td>ЭМДТ</td><td>61.1%</td><td>33.3%</td><td>5.6%</td><td>0.0%</td><td>0.0%</td><td>91.1%</td></tr><tr><td>СЗЭТ</td><td>33.3%</td><td>26.7%</td><td>40.0%</td><td>0.0%</td><td>0.0%</td><td>78.7%</td></tr></table> Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний хэрэглэгчдийн үнэлгээнд 2026 оны 1-ээр улирлын хугацаанд Мэс заслын салбарын 7 тасаг төв, Дотрын салбарын 8 тасаг төвийн нийт 15 тасаг төвийн 513 өвчтөн судалгаанд хамрагдсан бөгөөд 22% нь судалгаанд цахим хэлбэрээр, 78% нь цаасан хэлбэрээр судалгаанд хамрагдсан. 2026 оны I улирлын хэвтэн эмчлүүлэгчдийн судалгаанд хамрагдсан нийт 513 үйлчлүүлэгчдийн хамрагдалтын байдлыг тасаг, төвөөр харьцуулан үзэхэд ЗТ (12.7%), НСМЗТ (10.9%), ЕМЗТ (9.4%), ЭНМЗТ (9.0%) хамгийн өндөр оролцоотой байсан. Харин УХСТ (2.5%), ДШСДТ (2.9%), VIP (3.9%), ХҮСҮСТ (3.9%) тус тус хамгийн бага оролцоотой байна. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор нийт байгууллагын албан хаагчдаас авах 10 асуулт бүхий асуулгыг бэлтгэн, хянуулах шатанд явж байгаа ба үр дүнд үндэслэн арга хэмжээ авахаар төлөвлөж байна.	Тасаг, төвийн нэр	“5” маш сайн	“4” сайн	“3” дунд	“2” муу	“1” маш муу	Дундаж үнэлгээ	Амбулатори	32.8%	50.6%	10.8%	2.5%	3.3%	81.4%	ДОТ	37.5%	51.6%	6.3%	3.1%	0.0%	83.8%	ЭМДТ	61.1%	33.3%	5.6%	0.0%	0.0%	91.1%	СЗЭТ	33.3%	26.7%	40.0%	0.0%	0.0%	78.7%
Тасаг, төвийн нэр	“5” маш сайн	“4” сайн	“3” дунд	“2” муу	“1” маш муу	Дундаж үнэлгээ																																	
Амбулатори	32.8%	50.6%	10.8%	2.5%	3.3%	81.4%																																	
ДОТ	37.5%	51.6%	6.3%	3.1%	0.0%	83.8%																																	
ЭМДТ	61.1%	33.3%	5.6%	0.0%	0.0%	91.1%																																	
СЗЭТ	33.3%	26.7%	40.0%	0.0%	0.0%	78.7%																																	
8	Албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал агуулга авч, түүний үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авах	Авсан судалгаа, хамрагдсан албан хаагчийн тоо, үр дүнд үндэслэн зохион байгуулсан арга хэмжээний тоо	Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх -Үр дүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	АВЛИГА БА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ Төрийн албан хаагчийн хяналт, хянагчдын судалгаа ЗААГААРЧИГАА - Асуулт бүрт зөвхөн нэг хариулт сонгоно уу. - Зөв хариулт нь “1” тэмдэгтэй тэмдэглэгдсэн байна - Хувийн утгаас нь асуулт бүрийн дээд хязгаарлагдсан байна 0-10 урс хариулт - Маш сайн (5-7 - Дунд зэрэг (0-4 - Хамтат сурвалж үнэмэлтгүй) 1. Асуулт: Авлига гэдэгт зөвхөн мөнгөн хэргийнхэн хаал хариул хамнаах үү? A) Тийм, зөвхөн мөнгөн хэргийнхэн хамнаах B) Түүх, бэлэг дурсгал, үйлчилгээ болон бусад аргаар байдал - хамнаах C) Зөвхөн үсгийн мөнгөн хэргийнхэн хаал хариул хамнаах D) Зөвхөн 1 сая төгрөгөөс дээш тэмдэглэгдсэн хамнаах 2. Асуулт: Төрийн албан хаагч хувийн бизнесийн хамт олонтой холбоотой үйлдвэр, байрлал, өмчлөх эрх бий үү? A) Үйлдвэр, байрлал, өмчлөх эрх бий B) Ашиг сонирхлын зөрчлөөс мэдэгдэх, тухайн асуудлаар татгалзах C) Дотоод хяналт мэдэгдэхгүйгээр хамнаах D) Хувийн бизнесийн хамт олонтой холбоотой 3. Асуулт: Хувийн, оролтын мэдээллийг хаан нийт тусгай хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий үү? A) Тусгай хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий B) 7 жил тусгай C) 1 жил тусгай D) 1 жил тусгай тусгай хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий 4. Асуулт: Төрийн албан хаагч гэдэгт зөвхөн мөнгөн хэргийнхэн хаал хариул хамнаах үү? A) Хувийн үсгийн хамнаах B) Төрийн албан хаагчийн хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий 5. Асуулт: Авлига гэдэгт зөвхөн мөнгөн хэргийнхэн хаал хариул хамнаах үү? A) Тийм, зөвхөн мөнгөн хэргийнхэн хамнаах B) Түүх, бэлэг дурсгал, үйлчилгээ болон бусад аргаар байдал - хамнаах C) Зөвхөн үсгийн мөнгөн хэргийнхэн хаал хариул хамнаах D) Зөвхөн 1 сая төгрөгөөс дээш тэмдэглэгдсэн хамнаах 6. Асуулт: Төрийн албан хаагч хувийн бизнесийн хамт олонтой холбоотой үйлдвэр, байрлал, өмчлөх эрх бий үү? A) Үйлдвэр, байрлал, өмчлөх эрх бий B) Ашиг сонирхлын зөрчлөөс мэдэгдэх, тухайн асуудлаар татгалзах C) Дотоод хяналт мэдэгдэхгүйгээр хамнаах D) Хувийн бизнесийн хамт олонтой холбоотой 7. Асуулт: Хувийн, оролтын мэдээллийг хаан нийт тусгай хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий үү? A) Тусгай хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий B) 7 жил тусгай C) 1 жил тусгай D) 1 жил тусгай тусгай хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий 8. Асуулт: Төрийн албан хаагч гэдэгт зөвхөн мөнгөн хэргийнхэн хаал хариул хамнаах үү? A) Хувийн үсгийн хамнаах B) Төрийн албан хаагчийн хяналт, хяналт, хянагчдын судалгаа бий																																			

Зураг. Хянагдаж буй асуулга

Зураг. Хянагдаж буй асуулга

9	Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	1 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх	Байгууллагын мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, дамжуулах талаар тусгагдсан эрх зүйн бичиг баримт болох "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хориглох заалтууд"-г дэлгэрэнгүй байдлаар нийт 306 ажилтнуудад таниулах зорилготой лекц, сургалтын үеэр танилцуулав. Мөн тус хориглох заалтуудыг видео хэлбэрээр нийт ажилтнуудад хоёр удаа албан и-мэйл хаягаар хүргээд байна.   Зураг. Сургалтын явцаас
10	Удирдлагын зүгээс авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлж, олон нийтэд Энэ тухай мэдээлэх	Удирдлагын зүгээс мэдээлэгчийг хамгаалахаа нийт албан хаагчдад мэдэгдэж, мэдээлэл өгөх сувгуудыг сурталчлах. Тийм бол "1", үгүй бол "0"		Тайлант хугацаанд байгууллагын удирдлагын зүгээс авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэх чиглэлээр албан хаагчдад мэдээлэл, зөвлөмжийг тогтмол хүргэсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах утасны дугаар шинэчлэгдсэнтэй холбогдуулан мэдээллийн постер боловсруулж, байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулан нийт албан хаагч, иргэдэд мэдээлсэн. Мөн авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан видео контентуудыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээж, олон нийтэд хүргэсэн. Ингэснээр авлигын эсрэг мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэх сувгийн талаарх мэдээллийг иргэд, албан хаагчдад хүргэх чиглэлээр ажилласан. https://www.unte.moh.gov.mn/a/917 линкээр орж үзнэ үү.

				 
				Зураг 3. Мэдээллийн явцаас
11	Байгууллагын удирдах албан тушаалтнаас нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах	Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо	Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх	2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Авлигатай тэнцэх газрын ажилтан, комиссар Д.Балдандорж "Авлигын гэмт хэргийн тухай ойлголт" сэдвээр нийт 140 нэгжийн дарга, эрхлэгч, их эмч нарт зохион байгуулагдсан тус сургалтын үеэр комиссар Д.Балдандоржтой нээлттэй асуулт, хариулт явагдаж, ажилтнууд өөрсдийн санал бодлыг илэрхийлэн, мэргэжлийн албан хаагчаас мэдээллээ дэлгэрүүлэн авав. 
				Зураг. Сургалтын явцаас
12	Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг байгууллага бүр бүрэн хэрэгжүүлж ажиллах	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байх	2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хэрэгжүүлэх тус төлөвлөгөөний нийт 12 ажлаас 12 нь тодорхой хэмжээнд хэрэгжсэн болон хэрэгжиж эхэлсэн гэж үзэж байна. Хэрэгжилтийн хувь – 85 %